

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 дугаар сарын 07

Дугаар А/14

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.3, 16.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг дүүргийн Салбар зөвлөлийн гишүүн байгууллагуудад даалгасугай.

3.Төлөвлөгөөнд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын даргын 2024
оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/14
дүгээр захирамжийн хавсралт

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах, нийгмийн дэг журмыг бэхжүүлж, иргэний ухамсар, соёлыг төлөвшүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд нөлөөлж буй шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын ажил, арга хэмжээг ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэгтэйгээр зохион байгуулахад 2024 оны төлөвлөгөөний зорилго оршино.

Нэг.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын талаар:

Д/д	Хамрах хүрээ	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв		Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин	Зорилтот түвшин, хүрэх үр дүн	Хугацаа (улирлаар)	Хариуцах нэгж, байгууллага	Хамтран хэрэгжүүлэх нэгж, байгууллага
			Хэмжээ мян.төг-өөр	Санхүүгийн эх үүсвэр						
Төлөвлөгөөний зорилго 1- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий чиглэлийн хүрээнд										
1.1	<i>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтийг хангуулах талаар авч хэрэгжүүлэх чиглэлээр:</i>									
1.1.1	Зөвлөлийн гишүүн байгууллага	Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүд батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр Ажлын албанд ирүүлэх	-	-	2 удаагийн тайлан ирүүлэх	100%	Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн гүйцэтгэлийн тайланг салбар зөвлөлийн гишүүн байгууллагууд хагас, бүтэн жилээр Ажлын албанд ирүүлж үр дүнг тооцож ажилласан байна.	I-IV улирал	Зөвлөлийн гишүүн байгууллага	Зөвлөлийн гишүүн байгууллага

1.1.2	Зөвлөлийн гишүүн байгууллага	Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах	Салбар зөвлөлийн гишүүн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэнээр ажлын уялдаа холбоо хамтын ажиллагаа сайжрах, ажлын бүтээмж дээшилсэн байна.	I-IV улирал	Зөвлөлийн гишүүн байгууллага	Зөвлөлийн гишүүн байгууллага
1.1.3	Иргэнд	Гэмт хэрэг, зөрчлийн талаар ач холбогдол бүхий мэдээлэл ирүүлсэн иргэдийг урамшуулах (мэдээллийг иргэдээс төлбөртэй авах ГХЗУСтХ 33.1.1, 33.1.2 дахь заалт)	.	.	Гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах	100%	Нуугдмал болон бусад гэмт хэрэг, зөрчлийн илрүүлэлт нэмэгдэж, олон нийтийн оролцоо хангагдсан байна.	I-IV улирал	ЦГ	ДГХУСАЗСЗ
1.1.4	Иргэд, алба хаагчид	Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн цагдаа, олон нийтийн эргүүл, хүүхэд хамгаалагч, хэсгийн ахлагч нарыг татан оролцуулж эрх зүйн мэдлэг нэмэгдүүлэх, мэдээ мэдээллээр хангах зорилгоор сургалт зохион байгуулах, зөвлөмж мэдээлэл өгч хамтран ажиллах, урамшуулах (ГХЗУСтХ 34.1, 46.5.1 дэх хэсэг)	.	.	Гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах	100%	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд тодорхой ахиц гарч ажилласан байна.	I-IV улирал	ЦГ, ЗЦХ	ДГХУСАЗСЗ
1.1.5	Зөвлөлийн гишүүн байгууллагуудын удирдлага, алба хаагчид	Салбар зөвлөлийн гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх, уялдаа холбоо хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр сургалт, тодорхой арга хэмжээг зохион байгуулж ажиллах, салбар зөвлөлийн гишүүдийн дунд тэмцээн, уралдаан зохион байгуулах, гадаад дотоод хамтын ажиллагааг сайжруулж туршлага судлах боломж бололцоог хангаж ажиллах	Салбар зөвлөлийн гишүүн байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сайжирна.	I-IV улирал	ДИТХ	Зөвлөлийн гишүүн байгууллага

1.1.6	ЕБС-ийн сурагчид	“Эрт мэдвэл илүү аюулгүй” хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн дунд болон ахлах ангийн сурагчдыг дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүн байгууллагын үйл ажиллагаатай танилцах ажлыг зохион байгуулах (ЭХАШШ, ЦГ, ПГ, Цэргийн анги нэгтгэлийн үйл ажиллагаатай танилцах)	.	.	Хамрагдсан сурагчдын тоо	100%	Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт, гарах шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх, хэрхэн өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдлэг мэдээлэлтэй болсон байна.	I-IV улирал	ДИТХ	Зөвлөлийн гишүүн байгууллага
1.1.7	СӨБ, ЕБС-ийн сурагчид	“Эрт мэдвэл илүү аюулгүй” хөтөлбөрийн хүрээнд СӨБ-ийн хүүхэд, багачууд, ЕБС-ийн бага ангийн 13 хүртэлх насны хүүхэд, багачуудыг Тийболл спортоор дамжуулан зөв дадал хэвшил, ёс зүйтэй иргэнийг төлөвшүүлэх, багаар хамтран ажиллах чадварыг нэмэгдүүлэх, чөлөөт цагаараа бие бялдараа хөгжүүлэх, цагийг үр дүнтэй өнгөрүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх ажил, арга хэмжээг дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулах ажил (Улсын хэмжээний болон дотоодын тэмцээн уралдаанд оролцох, шаардлагатай техник хэрэгсэл, хувцас хэрэгсэл, дадлагажуулах багш, дасгалжуулагчийг урамшуулах, гадаад, дотоодын томилолтыг санхүүжүүлэх) -ыг хэрэгжүүлэх	.	.	Хамрагдсан хүүхэд, багачууд, сурагчдын тоо	100%	Баянзүрх дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт, гарч буй шалтгаан нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх, хэрхэн өөрийгөө болон бусдыг хамгаалах талаар мэдлэг мэдээлэлтэй болсон байна.	I-IV улирал	ДИТХ	Зөвлөлийн гишүүн байгууллага
1.1.8	Хүүхэд, залуучууд	“Эрт мэдвэл илүү аюулгүй” хөтөлбөрийн хүрээнд Баянзүрх дүүргийн өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих, сургагч багшаар бэлтгэх цогц хөтөлбөр хэрэгжүүлэх	.	.	Хамрагдсан хүүхэд, залуучуудын тоо	100%	Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангасан байна.	I-IV улирал	ДИТХ	Зөвлөлийн гишүүн байгууллага

1.1.9	ЕБС-ийн сурагчид	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн Ерөнхий боловсролын сургууль орчмын бүсэд явган хүний гарцын гэрэлтүүлэг хийх ажлыг гүйцэтгэх	.	НИТХ	Гүйцэтгэсэн ажлын үр дүн	100%	Сургууль орчмын бүсийн аюулгүй байдлыг хангаж явган зорчигч, хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд тодорхой үр дүнд хүрсэн байна.	I-IV улирал	ДИТХ	Зөвлөлийн гишүүн байгууллага
1.1.10	ЕБС-ийн сурагчид	Хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр (сургууль, цэцэрлэг орчмын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх, хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон аргаар замын хөдөлгөөнд явган болон зорчигч хэлбэрээр аюулгүй оролцох дадлыг эзэмшүүлэх, таниулах мини дром, сургалтын танхимыг тохижуулах, төлөвлөгөөт ажил, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах)-ийг хэрэгжүүлэх	.	.	Сургалт, мини дромд хамрагдсан сурагчдын тоо	100%	Хүүхэд багачуудын замын хөдөлгөөнд хэрхэн зөв оролцох талаар мэдлэг, мэдээлэл дээшилсэн байна. Энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурсан байна.	I-IV улирал	ДИТХ	Зөвлөлийн гишүүн байгууллага
1.1.11	Хүүхэд, багачууд, иргэд, олон нийт	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд насанд хүрээгүй хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг таслан зогсоох хөтөлбөр (нийтийн хэв журмыг хамгаалахад олон нийтийг татан оролцуулах, соён гэгээрүүлэх замаар насанд хүрээгүй хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн аливаа хэлбэрийг таслан зогсоох, хүүхдийн аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах ажил, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах)-ийг хэрэгжүүлэх	.	.	Гэмт хэрэг, зөрчилд өртсөн хүүхдийн тоог бууруулах	100%	Иргэдийн мэдээлэх үүрэг, илрүүлэлт нэмэгдсэн, энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурсан, хүүхдүүд өөрийгөө хамгаалж сурсан байна.	I-IV улирал	ДИТХ	Зөвлөлийн гишүүн байгууллага, ТББ
Төлөвлөгөөний зорилго 2- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай чиглэлийн хүрээнд										
2.1	<i>Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:</i>									

2.1.1	ЕБС-ийн сурагчид	Хүүхдийг зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ерөнхий боловсролын сургууль орчмын бүсэд замын хөдөлгөөнд оролцогчдын сонор сэрэмжийг дээшлүүлэх зорилгоор “Анхааруулга бүхий шар бүс” төсөл хэрэгжүүлэх (ЕБ-ын 102 дугаар сургууль)	.	.	Хамрагдсан сурагчдын тоо	100%	Сургууль орчмын зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрлөөс урьдчилан сэргийлэх ажилд үр дүн гарна.	III-IV улирал	ЦГ	ЗДТГ, БХ
2.1.2	ЕБС, СӨБ	Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн гадна, дотор орчмыг камержуулах	.	.	Байршуулсан тоо хэмжээ	100%	Сургууль, цэцэрлэгийн орчмын гэмт хэрэг, зөрчлийн тоо буурсан байна.	I-IV улирал	БХ	ЗДТГ, ЦГ
2.1.3	ЕБС, СӨБ	Зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн гадна орчмын тэмдэг, тэмдэглэгээг нэмэгдүүлэх	.	.	Байршуулсан тоо хэмжээ	100%	Хүүхэд, багачууд зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд тодорхой үр дүнд хүрсэн байна.	I-IV улирал	БХ	ЗДТГ, ЗЦХ
2.1.4	Иргэд, олон нийтэд	Хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх замын хөдөлгөөнд аюулгүй зөв боловсон оролцох мэдлэг олгох “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”, “Бяцхан зорчигч”, “Шар дарцаг”, “Хичээх өдөр”, “Хичээл эхэллээ” зэрэг арга хэмжээг зохион байгуулах	.	.	Хамрагдсан иргэд, хүүхэд, багачуудын тоо	100%	Иргэд олон нийтийг аюулгүй зөв боловсон замын хөдөлгөөнд оролцоход мэдлэг олгож, мэдээллээр хангасан байна.	II улирал	ЗЦХ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.1.5	Иргэд, ажилтан албан хаагч, сурагчид	Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийг иргэд олон нийтэд сурталчлан таниулах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх иргэдэд ойлгомжтой хэлбэрээр гарын авлага бэлтгэж тараах	.	.	Хамрагдсан иргэдийн тоо	100%	Шинээр батлагдсан Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар хууль эрх зүйн мэдээллээр иргэдийг хангаж ажилласан байна.	I улирал	ЗЦХ, ТББ	Зөвлөлийн гишүүн байгууллага

2.1.6	ЕБС сурагчид	Жил бүрийн 10, 11 дүгээр сард ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ногоон гэрэл-Цагаан шугам 2024” тэмцээнийг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах	.	.	Хамрагдсан сурагчдын тоо	100%	Хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч нарын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг, мэдээлэл нэмэгдэнэ.	IV улирал	ЗЦХ, БХ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.1.7	Сургуулийн өмнөх насны хүүхэд	Жил бүр сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхдүүдийн дунд уламжлал болгон зохион байгуулдаг “Замын хөдөлгөөний цагаан толгой 2024” тэмцээнийг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах	.	.	Хамрагдсан хүүхэд, багачуудын	100%	Хүүхэд, эцэг, эх, асран хамгаалагч нарын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг нэмэгдэнэ.	II улирал	ЗЦХ, БХ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.1.8	ЕБС-ийн 14 нас хүртэлх сурагчид	Хүүхдийг зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор эцэг, эх, асран хамгаалагч нарын дунд “Нэг дүгээрт хүүхэд өдөрлөг арга хэмжээг зохион байгуулах”	.	.	Хамрагдсан хүүхэд, багачуудын	100%	Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа иргэдэд хүрч, иргэдийн хууль эрх зүйн мэдлэг дээшилнэ.	II улирал	ЗЦХ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.1.9	Иргэд, олон нийтэд	Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, иргэд жолооч нарыг зөв дадалд хэвшүүлэх зорилгоор жил бүр цагдаагийн байгууллагаас 6, 7, 8, 9 дүгээр саруудад зохион байгуулагдах “Хөдөлгөөний соёл 2024” нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнд шаардагдах зардал шийдвэрлэх	.	.	Нэгдсэн арга хэмжээнд хамрагдсан	100%	Иргэдийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дээшилж, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил тодорхой хэмжээгээр буурсан үзүүлэлттэй байна.	II-III улирал	ЗЦХ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.1.10	СӨБ, ЕБС-ийн сурагчид	Сургуулийн өмнөх насны болон бага ангийн боловсролын системд замын хөдөлгөөний дүрмийн хичээлийг хүүхдэд ойлгомжтой анимейшн, контент хэлбэрээр олон нийтэд хүргэх	.	.	Цахим түгээлтийн тоо	100%	Сургуулийн өмнөх болон сургуулийн насны сурагч, хүүхдүүд замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгтэй болно.	I-IV улирал	ЗЦХ, ТББ	Зөвлөлийн гишүүн байгууллага

2.1.11	ЕБС-ийн нийгмийн ажилтан, сурагчид	Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран шинэлэг байдлаар 2 үе шаттайгаар сургалт зохион байгуулах	,	,	Сургалтын тоо	100%	Тээврийн хэрэгслийн ашиглалт журмын эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан багш, эцэг эхийн холбоог сайжруулж замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.	II-III улиралд	ЗЦХ, ТББ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.1.12	ЕБС-ийн сурагчид	Ерөнхий боловсролын сурагчдын төрөл бүрийн хувцас, цүнх малгай, бээлий болон бусад эд зүйлс дээр зүүх боломжтой цацруулагч зүүж замын хөдөлгөөнд оролцуулах	,	,	Хамрагдсан сурагчдын тоо	100%	Шөнө оройн цагаар болон гэрэлтүүлэг хэрэгсэл байхгүй гудамж талбайд хүүхэд зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.	I-II улирал	ЗЦХ, ТББ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.1.13	Иргэд, олон нийт, ЕБС-ийн сурагчид, хүүхэд, багачууд	Улаанбаатар хотыг хөгжүүлэх хүн төвтэй бодлого, орчин төвтэй шийдэл, төлөвлөлт төвтэй хөгжил бодлогын хүрээнд иргэдийн ая тухтай, замын хөдөлгөөнд аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, авто машины хөдөлгөөнд саад учруулахгүй байх явган зорчигчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тус дүүргийн нутаг дэвсгэрт “Нүхэн болон гүүрэн гарц”-ны загвар зураг төслийг мэргэжлийн байгууллага, олон нийтийн оролцоотой тодорхойлох зорилгоор загвар зураг төсөл боловсруулах уралдааныг зарлах	,	,	,	,	Сургууль орчмын бүсийн аюулгүй байдлыг хангаж явган зорчигч, хүүхдийг зам тээврийн осолд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд тодорхой үр дүнд хүрсэн байна.	I-IV улирал	ЗЦХ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.1.14	Иргэд, олон нийтэд	Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, иргэд жолооч нарыг зөв дадалд хэвшүүлэх зорилгоор контентыг бэлтгэн түгээх	,	,	Цахим түгээлтийн тоо	100%	Иргэдийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг дээшилж, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил тодорхой хэмжээгээр буурсан үзүүлэлттэй байна.	II-III улирал	ДИТХ	ЗЦХ

2.1.15	Оюутан, сурагчид, хүүхэд, багачууд	Их, дээд сургууль болон коллеж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 2023-2024 оны хичээлийн жил эхлэхтэй холбогдуулан оюутан, сурагч, хүүхэд багачуудыг гэмт хэрэг зөрчил, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах, хяналтыг эрчимжүүлэх чиглэлээр “Хичээл эхэллээ” ерөнхий арга хэмжээг дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах	.	.	Хамрагдсан оюутан, сурагчид, хүүхэд, багачуудын тоо	100%	Хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулж төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.	I-IV улирал	ЗЦХ, ТББ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.2	<i>Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:</i>									
2.2.1	Албан хаагчид	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор нөлөөний талаар хууль сахиулах байгууллагын алба хаагчид, олон нийтийн цагдаа, төрийн байгууллагын албан хаагчид, хорооны нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нарт урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах	.	.	Сургалтын тоо, хамрагдсан албан хаагчдын тоо	100%	Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, мэдлэгтэй болгох нь сургалтын гол зорилго болно.	I-IV улирал	ДИТХ, ЗДТГ, ЦГ	ЭХАШШ, СЭМҮТ
2.2.2	Иргэд, олон нийт	Дүүргийн Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй үйлчлүүлэгч, иргэдэд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор нөлөө, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	.	.	Сургалтын тоо, хамрагдсан	100%	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор нөлөө, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн иргэд урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээ мэдээллээр хангагдсан байна.	I-IV улирал	ЭМТ	ӨЭМТ

2.2.3	ЕБС-ийн сурагчид	Өсвөр насны хүүхэд, залуучуудад зориулан электрон тамхины хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх, халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажлыг үе шаттай зохион байгуулах	.	.	Сургалтын тоо	100%	Өсвөр үе, хүүхэд, залуучуудад электрон тамхины хор хөнөөлийг таниулснаар хорт зуршлаас татгалзах мэдлэгтэй болсон байна.	I-IV улирал	ЦГ, ЭМТ	БХ, ӨЭМТ
2.2.4	Албадлагын арга хэмжээ авагдсан этгээдэд	Хар тамхи, мансууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох албадлагын арга хэмжээ авагдсан этгээдүүдэд мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хор хөнөөлийн талаар зөвлөмж, зөвлөгөө тогтмол өгөх, урьдчилан сэргийлэх, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах	.	.	Сургалтын тоо	100%	Хар тамхи, мансууруулах бодисын сөрөг нөлөө түүний хор уршгийг таниулах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдлэгтэй болж урьдчилан сэргийлнэ.	Сар бүр	НШШГГ-ын Баянзүрх дүүрэг	Зөвлөлийн гишүүн байгууллага, ЦЕГ-ын ХТТХ
2.2.5	Оюутан, сурагчид	Хар тамхи, мансууруулах бодисын тестээр хангах, ерөнхий боловсролын сургууль, Их дээд сургуулиудад хангах, үзлэг, шалгалтын ажлыг улиралд 1 удаа зохион байгуулах	.	.	Хамрагдсан оюутан, сурагчдын тоо	100%	Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарна.	III-IV улирал	ЦГ, БХ	ЦЕГ-ын ХТТХ
2.2.6	Эцэг, эх, асран хамгаалагч, оюутан, сурагчид	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн болон төрийн өмчийн бус Ерөнхий боловсролын сургууль, Их дээд сургуулиудын оюутнууд, эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтан, албан хаагчдад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис түүний хор уршигийг таниулах чиглэлээр сургалтыг зохион байгуулах	.	.	Гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах	100%	Өсвөр үе, хүүхэд, залуучууд аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байна. Мөн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн мэдлэг дээшилсэн байна.	I-IV улирал	ДИТХ, ЦГ, ХГБХХХ, БХ	ЦЕГ-ын ХТТХ, Их дээд сургууль, дүүргийн Өсвөрийн улаан загалмай, хүүхдийн зөвлөл, охид, хөвгүүдийн зөвлөл
2.3	Эрүүгийн хуулийн 12, 13 дугаар бүлэгт заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:									

2.3.1	Албан хаагчид	Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, хүчиндэх, дээрэмдэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогч төвтэй, хүүхдэд ээлтэй аргаар гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах сэдвээр хууль сахиулах байгууллагын алба хаагч, олон нийтийн цагдаа, хороодын нийгмийн ажилтан, өрхийн эмч нарт сургалт зохион байгуулах	.	.	Сургалтын тоо, хамрагдсан албан хаагчдын тоо	100%	Албан хаагчдын эрх зүйн мэдлэг нэмэгдсэн байна.	I-IV улирал	ЭХАШШ, ДХИС	ДИТХ, ЗДТГ, ЦГ, ЭМТ
2.3.2	Өсвөр үе хүүхдэд	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдүүд, мөн гэмт хэргийн хохирогч, холбогдогч, хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх буюу өмгөөллийн үйлчилгээ үзүүлэхэд хамтран ажиллах	.	.	Үйлчилгээ үзүүлсэн хувь	100%	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж ажилласан байна.	IV улирал	ХГБХХХ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.3.3	Иргэд, олон нийтэд	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдэж буй бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, судалгаанд үндэслэн сургалт зохион байгуулах	.	.	Сургалтад хамрагдсан иргэдийн	100%	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг дүүргийн хэмжээнд нэг мөр хангуулан ажиллахад чиглэсэн байна.	II улирал	ПГ, ЦГ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.3.4	Албан хаагчид	Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх буюу "сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах ажиллагаанд хүний эрхийн асуудал, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед хүнийг саатуулах талаарх эрх зүйн орчинд хийсэн шинжилгээ" сэдвийн хүрээнд сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	.	.	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	100%	Мөрдөн шалгах ажиллагааны явцад хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчихгүй байх, тухайлбал: сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүнийг саатуулахад гарч буй хүний эрхийн зөрчлийг арилгах, зөрчил шалган шийдвэрлэх болон мөрдөн шалгах ажиллагаанд оролцож буй прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтнуудыг чадавхжуулж ажилласан байна.	I улиралд	ПГ	ХЭУКомисс, ЦЕГ, ДЭХАШШ, УЕП-ын дэргэдэх сургалт судалгааны хүрээлэн

2.3.5	Албадлагын арга хэмжээ авагдсан хүмүүжигч нарт	Шүүхээс Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2.2 дахь заалтад заасны дагуу зан үйлд нөлөөлөх сургалтад хамрагдах албадлагын арга хэмжээ авагдсан хүмүүжигч нарыг сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах	.	.	Сургалтад хамрагдсан хүмүүжигч нарын тоо	100%	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.5.1 дэх заалтад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн бус байгууллага, иргэд, байгууллагын дунд зохион байгуулж байгаа сургалт, сурталчилгааны ажлын зардлыг санхүүжүүлэх” гэж заасны дагуу сургалтад хамруулсан байна.	I-IV улирал	НШШГТ-ын Баянзүрх дүүрэг	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.3.6	Хүмүүжигч нарт	Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн болон Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллаж хяналт тогтоосон хүмүүжигч нарт ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, сэтгэлзүйн сургалтад хамруулах	.	.	Сургалтад хамрагдсан хүмүүжигч нарын тоо	100%	Зан үйлээ засах албадлагын арга хэмжээ авагдсан, хугацааны өмнө суллаж хяналт тогтоосон этгээдийг зан үйл засах болон ажил мэргэжлийн чиг баримжаа, чадамжийн гэрчилгээ олгох сургалтад хамруулахад чиглэнэ.	I-IV улирал	ПГ, НШШГТ-ын Баянзүрх дүүрэг	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.3.7	Эцэг, эх, асран хамгаалагч, СӨБ, ЕБС-ийн багш нарт	Хүүхдийг бэлгийн хүчирхийлэл, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, оюутан сурагчид, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, далд хэлбэрт үйлдэгдсэн хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн хэргийн талаар мэдээлэл цуглуулах, илрүүлэх, шалгаж шийдвэрлэх ажиллагааг эрчимжүүлэх, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	.	.	Сургалтын тоо, хамрагдсан албан хаагчдын тоо	100%	Иргэдийн мэдээлэх үүрэг болон энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдсэн байна.	II-III улирал	ЦГ, ХГБХХХ	Зөвлөлийн гишүүн байгууллага

2.3.8	Асрамжийн төвд байгаа хүүхэд, багачууд	Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдэж буй бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, судалгаанд үндэслэн арга хэмжээ, сургалт зохион байгуулах	.	.	Сургалтын тоо	100%	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.	I-IV улирал	ПГ, ЦГ	ДИТХ, дүүргийн Өсвөрийн улаан загалмай, хүүхдийн зөвлөл, охид, хөвгүүдийн зөвлөл
2.3.9	ЕБС-ийн багш, ажилтан, сурагчид	Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн болон төрийн өмчийн бус сургуулийн багш, ажилтан, сурагчдад яриа таниулга хийх, сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	.	.	Сургалтын тоо, хамрагдсан албан хаагчид, сурагчдын тоо	100%	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.	I-II улирал	ЦГ	ПГ, БХ, ЭМТ
2.4	<i>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:</i>									
Зорилт: Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах зорилгоор ажил, арга хэмжээ, нөлөөллийн аян зохион байгуулах, үр дүнг тооцох										
2.4.1	Хамтарсан багийн гишүүдэд	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хороодын Хамтарсан багийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөмж хүргүүлэх, үр дүнг хэлэлцэх, хяналт шалгалт хийх	.	.	Хамтарсан багт хийсэн хяналт, шалгалтын тоо	100%	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлж ажилласан байна.	I-IV улирал	ПГ, ХГБХХХ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.4.2	Албан хаагчид	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор албан хаагчид болон түүний гэр бүлийн гишүүдэд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн төлөвлөлтийн талаар сургалт зохион байгуулах	.	.	Сургалтын тоо	100%	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ үзүүлсэн байна.	I-IV улирал	ХГБХХХ	Зөвлөлийн гишүүн байгууллага

2.4.3	Хамтарсан баг	Гэр бүлийн тухай хуулийн талаар эрх зүйн мэдлэг олгох сургалт зохион байгуулах	'	'	Сургалтын тоо	100%	Гэр бүлийн тухай хуулийн талаар ойлголт өгч, гэр бүлийн боловсрол, хуулийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.	I улиралд	ИХАШШ	ЗДТГ
2.4.4	Зорилтот иргэд	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж холбогдох арга хэмжээ авах ажлыг зохион байгуулж ажиллах	'	'	'	'	Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн талаарх ойлголтыг өгөх, түүнээс урьдчилан сэргийлэх, хор уршгийг ойлгуулахад нөлөөлөл үзүүлсэн байна.	III улирал	ПГ	ЗДТГ, ЦГ
2.4.5	Хүчирхийлэл үйлдэгч нар	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарт чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ, сургалт, өдөрлөгийг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах	'	'	Сургалтын тоо	100%	Хүчирхийлэл үйлдэгчид засрал хүмүүжил олгох, нөлөөллийн сургалтад үе шаттай хамруулснаар нийгэмших нөхцөлийг бүрдүүлнэ.	I-IV улирал	ЦГ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.4.6	Хүүхэд, багачууд	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, холбон зуучлах чиглэлийн хүрээнд “Хүүхэд хамгаалал 2024” арга хэмжээг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах	'	'	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ	100%	Эрсдэлт бүлгийн хүүхдийг илрүүлэх, хариу арга хэмжээ авч ажиллана.	I-IV улирал	ЦГ	ХГБХХХ, Хамтарсан баг
2.4.7	Иргэд, олон нийт	Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр сэрэмжлүүлэг, нийтлэл, нэвтрүүлэг, богино хэмжээний видео шторк бэлтгэж, иргэд олон нийтэд хүргэх	'	'	Цахим түгээлтийн тоо	100%	Ажлын үр дүн дээшилж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо сайжирна.	I-III улирал	ЦГ	Зөвлөлийн гишүүн байгууллага

2.4.8	Хүчирхийлэл үйлдэгч нарт	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх хэсэг болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/73 дугаар тушаалаар батлагдсан Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмын дагуу хүчирхийлэл үйлдэгч нарт зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг дүүргийн хэмжээнд 2 удаа зохион байгуулах, үр дүнг тооцож ажиллах	.	.	Сургалтын тоо	100%	Гэр бүлийн хүчирхийлэл дахин давтан үйлдэгдэхээс сэргийлж, хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд зохих нөлөөлөл үзүүлнэ.	I, III улирал	НЦҮТ, ЦГ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.4.9	Хүчирхийлэл үйлдэгч нар	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарын зан үйлд нөлөөлөл үзүүлэх зорилгоор дахин давтан хүчирхийлэл үйлдэж буй 10-15 иргэнийг сонгон авч, мэргэжлийн байгууллагатай хамтран урт хугацааны сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах	.	.	Гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах	100%	Хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд зохих нөлөөлөл үзүүлсний үндсэн дээр дахин давтан хүчирхийлэл үйлдэхээс сэргийлнэ.	I-IV улирал	НЦҮТ	ЦГ, ЗДТГ, Хороодын Хамтарсан баг, ТББ
2.5	<i>Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:</i>									
2.5.1	ЕБС-ийн сурагчид	Ерөнхий боловсролын сургуулиудад “Эко бүлгэм”-ийг байгуулж, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн талаар ойлголт, мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллах	.	.	Хамрагдсан сургуулийн тоо	100%	Сурагч хүүхдүүд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн талаар ойлголттой болж, эх дэлхийгээ хайрлан хамгаалах үзэл бодол, мэдээ мэдээлэлтэй болсон байна.	I улирал	ЦГ	БХ
2.5.2	Иргэд, олон нийт	Хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зорилгоор арга хэмжээ зохион байгуулах	.	.	Зохион байгуулсан арга	100%	Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн тоо буурсан байна.	III, IV улирал	ЦГ, ОБХ	Зөвлөлийн гишүүн байгууллага

2.5.3	Иргэд, олон нийт	Гэр хорооллын айл өрхүүдийн түлшний хэрэглээнд хяналт тавьж, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж, сэрэмжлүүлэг бэлтгэж хүргэх	.	.	Цахим түгээлтийн тоо	100%	Түүхий нүүрс хэрэглэхгүй байх, угаарын хийн хордлогод өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан байна.	I, IV улирал	ЦГ, ОБХ	ЗДТГ, 43 хороод
2.5.4	Иргэд, олон нийт	Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хуулийн мэдлэг нэмэгдүүлэх сэрэмжлүүлэг бэлтгэж тараах ажлыг зохион байгуулах	.	.	Хамрагдсан иргэдийн тоо	100%	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг дүүргийн хэмжээнд нэг мөр хангуулан ажилласан байна.	I-IV улирал	ПГ, ЦГ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.5.5	ЕБС-ийн багш, ажилтан нарт	Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтыг зохион байгуулах	.	.	Сургалтын тоо, хамрагдсан албан хаагчдын	100%	Багш, ажилтан алба хаагчдыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулж, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг дээшилнэ.	II улирал	ЦГ	БХ
2.5.6	11, 20, 33, 35 дугаар хороодын нутаг дэвсгэр	Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт үхсэн мал, амьтны хүүр, сэг зэм зэргээс үүдэн байгаль орчин бохирдох, мал, амьтны халдварт өвчин дамжин тархах эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор үхсэн мал, амьтны хүүр, сэг зэмийг устгах, булшлах ажлыг зохион байгуулах	.	.	Эрсдэл үүсэхээс урьдчилан сэргийлэх	100%	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлсэн байна.	I-IV улирал	ДИТХ	ЗДТГ, Хороод
2.5.7	Иргэд, олон нийт	“Иргэд болон бага насны хүүхдийг гол, үер усны аюул эрсдэлээс урьдчилан сэргийлье” тусгай арга хэмжээний хүрээнд Туул голын эрэг дагуу урьдчилан сэргийлэх контент бэлтгэх, зураг зуруулах, зөвлөмж, сэрэмжлүүлэг хэвлүүлэх ажлыг зохион байгуулах	.	.	Гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах	100%	Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэлтэй болсон байна.	II-III улирал	ЦГ	Зөвлөлийн гишүүн байгууллага
2.6	<i>Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр</i>									

2.6.1	Иргэд, олон нийт	Мал, мах худалдан авч борлуулдаг цэгүүд, зах худалдааны төвүүдэд алба хаагчдыг эргүүлээр ажиллуулж мал хулгайлах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийх, үүнтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг бэлтгэх, цахим хуудсанд байршуулах, олон нийтэд түгээж ажиллах	.	.	Гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах	100%	Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэлтэй болсон байна.	IV улирал	ЦГ	Зөвлөлийн гишүүн байгууллага
